



**Монгол Улс: Усны засаглалыг сайжруулахад шинэлэг арга барил нэвтрүүлэх нь**

Төслийн нэр	Усны засаглалыг сайжруулахад шинэлэг арга барил нэвтрүүлэх нь
Төслийн дугаар	51099-001
Төсөл хэрэгжих улс	Монгол Улс
Төслийн статус	Батлагдсан
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Техникийн туслалцаа
Санхүүжилтийн эх үүсвэр / Мөнгөн дүн	<b>Техникийн туслалцаа 9440-МОН: Усны засаглалыг сайжруулахад шинэлэг арга барил нэвтрүүлэх нь</b> Ядуурлыг бууруулах Японы сан 1 сая ам.доллар
Холбогдох стратегийн зорилт	Байгаль орчинд ээлтэй тогтвортой өсөлт Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт
Өөрчлөлтийн чиглэлүүд	Засаглал ба чадавхийн хөгжил Мэдлэгт суурилсан шийдэл Түншлэл
Салбар / Дэд салбар	<b>Хөдөө аж ахуй, байгалийн баялаг ба хөдөөгийн хөгжил –</b> Усжуулалт – Хөдөөгийн усны бодлого, байгууллагын ба чадавхийн хөгжил – Усны нөөцөнд тулгуурласан байгалийн баялгийн менежмент <b>Ус ба бусад хотын дэд бүтэц, үйлчилгээ – Хотын ус хангамж</b>
Жендэрийн тэгш эрх ба жендэрийн тэгш эрхийн үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь	Жендэрийн элементгүй төсөл
Төслийн тодорхойлолт	Санал болгож буй техникийн туслалцааны төсөл нь голын сав газарт усны засаглалын үйл явцыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бөгөөд төслийн хүрээнд хэрэгжүүлсэн сайн туршлагыг Монгол Улс даяар, бүс нутгийн бусад голын сав газар өргөжүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх юм. Техникийн туслалцааны энэхүү төсөл сургалт явуулах, хийнгээ суралцах, мэдлэгийг хуваалцах, туршилтын жижиг төсөл хэрэгжүүлэх замаар чадавхийг бэхжүүлэх юм. Төсөл нь хэрэгжилтийн үед суралцсан зүйлс, авсан сургамжид дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах бөгөөд үүнийгээ цаашид удаан хугацаанд байгууллагын ба бодлогын өөрчлөлт шинэчлэл хийхэд ашиглана. Монгол Улс даяар голын сав газрын усны салбарын төлөвлөлт, менежментийн арга барилд ихээхэн өөрчлөлт авчрахыг зорьсон. Нийгэм, эдийн засгийн ач тус, үр ашиг авчрахын тулд усны

салбарын хөрөнгө оруулалт, дэд бүтцийн үр ашиг, тогтвортой байдлыг сайжруулна.

Уг техник туслалцааны төсөл нь АХБ-ны Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх 2017-2020 оны Түншлэлийн стратегитай уялдсан. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тодорхой заасан усны салбарт хүлээсэн үүрэг хариуцлагыг биелүүлэх талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамны гаргаж буй хүчин чармайлтыг дэмжих болно. АХБ-наас хийсэн Монгол Улсын Усны аюулгүй байдлын үнэлгээ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловсруулсан Монгол Улсын Усны менежментийн нэгдсэн төлөвлөгөө, Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө 2020 ба 2030 он хүртэлх хөгжлийн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй нийцэж байна. Энэхүү төсөл нь хөгжиж буй гишүүн орнуудад усны засаглалыг сайжруулах, устай холбоотой гамшигт тэсвэртэй байх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг хөгжүүлэх зорилго бүхий АХБ-ны Усны салбар дахь үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бүрэн уялдсан

---

Төслийн үндэслэл ба Улс/Бүс нутгийн стратегитэй уялдсан байдал

Монгол Улсын удаан хугацааны тогтвортой ба хүртээмжтэй өсөлт нь байгалийн баялгийн удирдлагаас ихээхэн хамаарч байна. Гэтэл нийгэм, эдийн засгийн хөгжил тус улсад хурдацтай явагдаж байгаа тул эдгээр нөөц баялгийн менежментэд ихээхэн бэрхшээл тулгарч байна. Үүгээр зогсохгүй, эдийн засгийн хөгжил, эрүүл мэнд, амьжиргаа, байгаль орчны тогтвортой байдал, гамшигт тэсвэртэй байдал зэргийг дэмжихийг тулд усны салбарт үр нөлөөтэй хөрөнгө оруулалтуудыг хийх шаардлага тулгарч байна. Цаашилбал, Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлт хэдийн ажиглагдаж эхэлсэн бөгөөд агаарын хэм, хүр тунадасны хэв маягт өөрчлөлт орсон нь бэлчээр муудах, мал аж ахуйн практикт сөргөөр нөлөөлж байна. Дулааны хэм нэмэгдэж, хур тунадасны хэлбэлзэл өссөнөөс усны ууршилт ихэссэн нь голын усны түвшин буурах, улирлын өөрчлөлт, хэлбэлзэл нэмэгдэх, нөхөн сэргээлт явагдахгүй байгаагаас гүний усны хангамж багасах зэрэг олон сөрөг үр дагаварт хүргэж байна.

Монгол Улсын Засгийн газар Усны нөөцийн нэгдсэн менежмент (УННМ)-ийн хууль эрх зүйн ба бүтэц зохион байгуулалтын орчинг бүрдүүлэх, мөн голын сав газрыг хамгаалах тухайд ихээхэн ахиц дэвшил гаргасан. 2010 онд, Монгол Улсын нутаг дэвсгэрийг голын 29 сав газарт хуваасан болно. Голын сав газрын зөвлөл (ГСГЗ) ба Голын сав газрын захиргааг (ГСГЗ)-аас бүрдсэн Голын сав газрын байгууллагуудыг (ГСГБ) бий болгосноор усны засаглалын төвлөрлийг сааруулж олон нийтийн оролцоог хангасан. 2012 оны Усны тухай хууль нь усны менежментийн ерөнхий хууль бөгөөд усны нөөцийн нэгдсэн менежментийн ерөнхий цар хүрээг бүрдүүлж өгсний дагуу ГСГЗ-уудыг үүсгэн байгуулсан. Гэвч чадавхи сул, нөөц хөрөнгө хязгаарлагдмал учир шаардлагатай байгаа 29 ГСГБ-уудаас дөнгөж 21-ийг байгуулж (i) голын сав газрын менежментийн төлөвлөгөөг дэмжих, ба (ii) эдгээр төлөвлөгөөг олон салбарын төлөөлөл болох оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Одоогоор үйлчилж буй төрийн бодлогуудад уул уурхайн салбар нь эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хүч гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг. Ус ашиглалт өндөртэй уул уурхайн үйл ажиллагаа нь бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн бүтцэд өөрчлөлт оруулж, Монголын хүн ам зүйн бүтцэд нөлөөлж, улмаар байгаль орчны ба усны аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлсэн.

---

Монгол Улсын ирээдүйн хөгжил нь усны нөөцийг хэрхэн удирдахаас ихээхэн хамаарах ба эрчим хүч, хүнсний аюулгүй байдлыг хангахад хэдийн хязгаарлагдмал болсон усны нөөцийг их хэмжээгээр шаардана. Хотжилт, хүн амын өсөлт, гамшгийн эрсдэлийн зохисгүй удирдлага, хөгжлийн төслүүд нь усны ашиглалтын тогтворгүй байдлыг бий болгож, мөн хэрэглэгчдийн дунд зөрчил үүсгэж болзошгүй. АХБ-наас Монгол Улсын усны аюулгүй байдлын үнэлгээнд, ялангуяа усны хомсдол өндөр байгаа хөдөө орон нутагт голын сав газрын түвшинд зохих бодлого, төлөвлөлт, дасан зохицох стратеги, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг бууруулах арга хэмжээ зэргийг боловсруулан, авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж дурджээ. Монгол Улсын өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээ, хүнсний аюулгүй байдал, эрэлт хэрэгцээг хангаж, нийгэм эдийн засгийн хөгжлийг бүрдүүлэхэд нэн ялангуяа уул уурхай, усны эрчим хүч, хөдөө аж ахуйн томоохон үйл ажиллагаатай голуудын сав газарт усны зохистой менежмент хийх нь нэн чухал байна. Монгол Улсад УННМ-ыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар байгууллага, бүтэц зохион байгуулалттай холбоотой саад бэрхшээлийг арилгах хэрэгтэй. Эдгээр бэрхшээлийг дурдвал: (i) засгийн газар ба аймаг, сумын орон нутгийн засгийн газар хоорондын уялдаа, зохицуулалт хязгаарлагдмал; (ii) ГСГБ-ууд тулгарч буй бэрхшээлийн даван туулах, мөн төв ба орон нутгийн засаг захиргаатай ажиллах эрх мэдэл, хүчин чадал хүрэлцээгүй; (iii) ГСГЗ-үүд хөгжөөгүй; (iv) ГСГЗ-үүдээр дамжуулан оролцогч талуудын зохицуулалт хийгддэггүй; (v) тоо баримт цуглуулах, хянах, удирдах ажил хангалтгүй (тархай бутархай, менежмент муу); (vi) усны менежментийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд техникийн нарийн мэргэжлийн ажилтан, санхүүгийн нөөц хөрөнгө дутмаг; ба (vii) усны менежментэд ашиглах арга хэрэгсэл үр ашиг муутай, өөр төрлийн загвар, хувилбарыг ашиглах сэдэл байхгүй байна.

Төслийн үр нөлөө	Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлт ба устай холбоотой гамшгийн үр дагаврыг илүү сайн ойлгож, хариу арга хэмжээ авах усны засаглал сайжирсан байна.
------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

#### Төслөөс хүлээгдэж буй үр дүн

Төслийн үр дүн	Сонгогдсон голын сав газрын усны салбарын төлөвлөлт, менежмент хийх чадавх сайжирсан байна
----------------	--------------------------------------------------------------------------------------------

Үр дүнд чиглэсэн ахиц дэвшил

#### Хэрэгжилтийн явц

Төслийн гүйцэтгэлүүд ба үйл ажиллагаа	Голын сав газрын бодлогын зөвлөмж боловсруулсан байна Голын сав газрын удирдлагын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна Голын сав газрын менежментийг сайжруулах арга хэмжээ, арга барилыг нэвтрүүлсэн байна
---------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Төслийн хэрэгжилтийн байдал (үр дүн, үйл ажиллагаа ба тулгарч буй асуудлууд)

Газарзүйн байршил	Үндэсний хэмжээнд
-------------------	-------------------

#### Байгаль орчин болон нийгмийн асуудлуудын хураангуй

Байгаль орчин

Албадан нүүлгэн шилжүүлэлт

Уугуул иргэд

### Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба хэлэлцүүлэг

Төслийн төлөвлөлтийн үед

Төслийн хэрэгжилтийн үед

### Бизнесийн боломжууд

Зөвлөх үйлчилгээ	АХБ-ны "Худалдан авах ажиллагааны бодлого" (2017 онд батлагдаж тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон), Төслийн удирдлагын журмын дагуу зөвлөх багийн сонгон шалгаруулна. Ингэхдээ чанар-үнэд суурилсан аргачлалыг ашиглан (чанар-үнийн харьцаа 90:10 байх) хялбаршуулсан техникийн санал авна. Техникийн туслалцааны төслийн мөн чанар ба туршилтын арга барилуудыг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн ур чадварын хэрэгцээг харгалзан үзэхэд энэ аргачлал уг төсөлд хамгийн сайн тохирно.
Худалдан авах ажиллагаа	АХБ-наас санхүүжих бүх худалдан авалтыг АХБ-ны "Худалдан авах ажиллагааны бодлого" (2017 онд батлагдаж тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон) ба АХБ-ны Зээлдэгч нарт зориулсан худалдан авах ажиллагааны журмын (2017 онд батлагдаж тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон) дагуу хийнэ.

### Хариуцагч талууд

АХБ-ны хариуцсан ажилтан	Мингүян Фан
АХБ-ны хариуцсан газар	Зүүн Азийн газар
АХБ-ны хариуцсан хэлтэс	Байгаль орчин, байгалийн баялаг ба хөдөө аж ахуйн хэлтэс
Хэрэгжүүлэгч байгууллага	<i>Байгаль орчин, аялал жуулчлалын яам Засгийн газрын байр II, Нэгдсэн үндэсний гудамж 5/2, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот 15160, Монгол Улс</i>

### Цагалбар

Төслийн үзэл баримтлалыг батлах	2017 оны 7 дугаар сарын 20
Баримт цуглуулах, судалгаа хийх	2017 оны 6 дугаар сарын 20-21
Удирдлагын хянан хэлэлцэх хурал	-
Төслийг батлах	2017 оны 12 дугаар сарын 5
Сүүлд хийгдсэн төслийн хяналт	-
Төслийн мэдээллийн тайланг сүүлд шинэчилсэн огноо	2018 оны 3 дугаар сарын 15

ТТ 9440-МОН

Чухал огноо

Төсөл батлагдсан огноо	Гэрээнд гарын үсэг зурсан огноо	Хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн огноо	Төсөл дуусах огноо		
			Анхны хувилбар	Шинэчилсэн	Бодит
2017 оны 12 сарын 5	-	-	2020 оны 6 сарын 30	-	-

Санхүүжилтын төлөвлөгөө / Ашиглалт

Зарцуулалт – өссөн дүнгээр

АХБ	Хамтарсан санхүүжилт	Хамтрагч тал				Нийт	Огноо	Дүн
		Засгийн газар	Төслөөс үр шим хүртэж буй хүмүүс	Төслийн спонсор	Бусад			
0.00	1,000,000.00	0.00	0.00	0.00	0.00	1,000,000.00	2017-12-5	0.00

Төслийн веб хуудас	<a href="https://www.adb.org/projects/51099-001/main">https://www.adb.org/projects/51099-001/main</a>
Мэдээлэл авахыг хүсвэл	<a href="http://www.adb.org/forms/request-information-form?subject=51099-001">http://www.adb.org/forms/request-information-form?subject=51099-001</a>
Төслийн мэдээллийн тайланг үүсгэсэн огноо	2018 оны 5 дугаар сарын 11

Төслийн мэдээллийн тайлан (ТМТ)-д төсөл, хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл агуулагддаг бөгөөд энэхүү тайлан нь тогтмол шинэчлэгддэг тул зарим нэг мэдээлэл тайлангийн эхний хувилбарт багтаагүй ч дараачийн хувилбарт орж болно. Төлөвлөж буй (батлагдаагүй) төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү ТМТ-г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа баталгааг олгохгүй. АХБ-ны зүгээс агуулгын чанарт ихээхэн анхаардаг хэдий ч энэхүү тайланд агуулагдсан мэдээллийг “байгаагаар нь” буюу арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэнд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүйгээр толилуулж байна. АХБ нь тайлан дахь мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлын талаарх ямар нэгэн баталгаа, эсхүл мэдэгдэл хийгээгүй болно.